

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Эрдэнэбат	Дугаар	L293
Оршин суугаа аймаг	Хөвсгөл аймаг	Оршин суугаа сум	Цагаан-Уул
Төрсөн газар	Цагаан – Уул сум	Төрсөн он	
Ажил мэргэжил	Лам		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Агарын хүрээ, Далайн хүрээ, Дордгойн хийд, Өвгөдийн хурал	Сүм хийдийн дугаар	ХӨЦУ 035, ХӨЦУ 034, ХӨЦУ 031, ХӨЦУ 033
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар едөр	2007 оны 6-р сарын 6	Ярилцлага авсан хүн	Д .Мөнхбат



Хөвсгөл аймгийн Цагаан-Уул сумын Агарын хүрээ, Далайн хүрээ, Дордгойн хийд

Мөнхбат: Ингээд Эрдэнэбат багш манай судалгааны багт Агарын хүрээний талаар өвөг дээдэс лам багш нар, нутгийн ахмадуудын үе дамжиж ярьж ирсэн аман мэдээллүүдээс дараах мэдээллүүдийг өгсөн юм аа.

Эрдэнэбат: Агарын хүрээ бол одоо үгүй, нэг зуугаас зуун тавь орчим лам нартай, дөрөв таван дугантай ийм байнгын хурал номын ажиллагаа явуулдаг ийм буяны үйл явуулдаг газар байсан юм аа.Энэ хийдийн шүтээн бол Очирваань буюу Чагдар шүтээнтэй байсан юм байгаа юм.Сүүлийн даасан лам нь Пэрэнлэй ловон гэдэг хүн байсан гэж ,тийм Пэрэнлэй цорж билүү. Пэрэнлэй цорж гэдэг хүн байсан гэж. Агарын цорж лам , хөгшчүүл ярьдаг юм. Агарын хүрээн дээр харин ер нь хятад пүүс гэж байлгадаггүй, тэр хил орчмын газар байсан болоод тэгдэг юм уу.Ер нь тийм хятад мятадын пүүс дэлгүүр энэ тэр гэж байдаггүй байсан гэж ярьдаг юм билээ.Тэр Дордгой бусад хүрээнүүд бол, зарим хүрээнүүд дээр бол байнгын тийм наймаа худалдаа эрхэлдэг. Дордгой гэхэд л хоёр ч пүүс байсан гэж.Агарын хүрээн дээр тийм пүүс мүүс тийм юм байлгадаггүй байсан. Угаасаа тийм

Энэхүү нэр дурдсан хүний аман ярилцлагын үгчилсэн тэмдэглэл нь зөвхөн ярилцагчийн хувийн мэдээллээс бүрдсэн болно.

© Монголын Урлагийн Зөвлөлийн Соёлын Өвийн Хөтөлбөр, Монголын Сүм хийдийн түүхэн товчоон

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

хууль дүрэмтэй байсан гэж ярьдаг юм билээ.Тэр бас зах хязгаар хил орчимд ч байсан болоод тэгдэг юм уу, ямар учиртай байсан юм билээ.Тэр харин бас Агарын хүрээний ном судрыг тэр үед шавилан сууж байсан Цэдэнхүү гэдэг лам бол нэлээн их бурхан, тэр шармал бурхнууд мөн тэр хийдийн зарим дуганы ганжир энэ тэрийг авч хадгалсан тийм буянтай, бас нэг дун яаж энэ тэр тийм юмыг авч хадгалсан тийм буянтай. Юмаа бас ингэж авч хадгалах гэж оролдсон лам болвол нэлээн олон байснаас амьд сэрүүн байсан нь тэр Цэдэнхүү гэж тэр лам байсан юм аа.Энэ Цэдэнхүү гуай бол тэр ганжир энэ тэрийг бол хийдийн ганжир юуг одоо орон нутгийг судлах музейд тавьсныг хагасыг нь олж аваад бид нар энэ хийдийнхээ, энэ Равданчойнхорлин хийдийнхээ ганжир болгож тавьсан.

Мөнхбат: Жас хөрөнгөний талар ямар байсан юм бол?

Эрдэнэбат: Тэр энэ тэрийг бол ёстой мэдэхгүй юм.

Далайн хүрээ

Мөнхбат: За бид нар өнөөдөр Хөвсгөл аймгийн болон Завхан аймгийн Их-Уул сум, Хөвсгөл аймгийн Цагаан-Уул сумын одоо нутгийн дээсийн хил залгаа орших Булнайн нурууны өвөр, Сангийн далай нуурын хойд биед орших Далайн хүрээ гэж алдаршсан, академич Ренчин гуайн жагсаалтанд Далайн хүрээ нэрээр орсон, тухайн үеийн Засагт хан аймгийн Эрдэнэдүүрэгч вангийн хошууны хүрээ хийд хурал номын томоохон газруудын нэг болох Далайн хүрээний тухай мэдээлэл цуглуулж сурвалжлага хийхээр мөн Цагаан-Уул сумын хийдийн хамба Эрдэнэбат багштай дараах ярилцлагыг үргэлжлүүлсэн юм аа.Тэгэхээр энэ Далайн хүрээ таны хуучилж байснаар бол бас нэлээд хэдэн жилийн тэртээ, ер нь энэ Эрдэнэ дүүрэгч вангийн хошууны томоохон хийд болох Тэсийн хүрээнээс ч өмнө байгуулагдсан хоёр зуу гаруй гурван зуу шахуу жилийн түүхтэй ийм хүрээ хийдийн газар гэж ойлгогдож байна.Тэгэхээр нэгэнт энэ хүрээнд шавилан сууж байсан хүмүүс бараг үндсэндээ энэ нутагт байхгүй болж.Тэгэхээр тэр одоо хүрээ хийдийн тухай таныг бага байхад одо идэр залуу байхад нутаг орны өвгөд хөгшид хуваргууд санваартнууд юу гэж ярьж ам дамжиж байсан, энэ хүрээний одоо онцлог, бусад хүрээ хийдүүдээс ямар онцлогтой байсан, ямар ямар хурал хурдаг байсан, ямар ямар одоо шүтээн сахиустай байсан, за жас сангийн хувьд хэрхэн яаж бэхжсэн байсан, сүм дуган нь одоо хэд хэдэн ямар ямар сүм дугантай байсан тухай мэдээллийг одоо бидэнд өгнө үү?

Эрдэнэбат: Сангийн далайн хүрээ бол их өвгөн хүрээ гэж өвгөн лам нар ярьдаг юм. Тэсийн хүрээнээс урьд байгуулагдсан гэж өвгөн лам нар хуучилдаг байсан юм. За энэ бол жас нэлээн их аж ахуй нь их тохижсон тийм баян.Ерөөсөө тэр...за тэгээд ганжуурын дуган, дарь эхийн дуган, хажидын дуган энэ тэр гээд ер нь долоо найман дугантай, хоёр зуугаад ламтай.Байнгын байдаг лам нар нь бол зуун тавь орчим лам нар хийд хүрээн дээрээ сууж хурал номынхоо үйл ажиллагааг явуулдаг. Цам гарахаас л бусад бүх үйл ажиллагааг бүгдийг нь явуулдаг тийм бас шашин номын томоохон төв байсан юм байна аа. Хийдийн шүтээн нь Гомбо шүтээнтэй байсан гэдэг юм, Гомбо.Тэгээд энэ хүрээний орчимд зуугийн хоёр ч ранжимба хүн байсан гэж.Нэг нь Гомпил ранжимба гэдэг. Нэг нь олон их шавьтай, их алдартай хүн байсан учраас тэр өвгөн лам нар ер нь бүгд шавь нар нь байсан байлгүй юм. Ранжимба багш гэдэг бол тэр ер нь зөвхөн энэ хүрээнд биш, ар Халх цаашилбал, Төвдөд

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

алдаршсан ранжимба байсан юм гэж Халхын долоон саат гэж нэрлэдэг тийм хүн байсан. Долоон бурхны нямба бүтээлгэ хийгээд цугаарантай нь үүлзсэн гэдэг домогтой тийм алдартай хүн сууж байсан юм аа гэж өвгөн лам нар ярьдаг байсан, тэнд. За энд тэр жас нь болвол их, аж ахуйн газар нь их баян. Олон мал хөрөнгөтэй тийм, тийм ч учраас үйл ажиллагаа нь сайхан явагддаг байсан гэж өвгөн лам нар хуучилдаг. Тэр Мэнтэвийн чог гэдэг хурлыг их хурдаг. Мэнтэв бурхны чог их дэлгэрсэн газар байсан, тэр ранжимба лам энэ тэр дэглэж гаргасан юм болов уу, хаанаасаа гарсан юм билээ. Мэнтэвийн чог бүтээл их хийдэг. Мэнтэвийн чог бусад чогнуудаасаа их илүү хурдаг. Аль ч чогийг хурдаг байснаасаа илүү тэр Мэнтэв бурхны чогийг их хурдаг байсан гэж өвгөн лам нар ярьдаг байсан юм аа.

Мөнхбат: За баярлалаа, таньд.

Дордгойн хийд

Мөнхбат: За өнөөдөр манай судалгааны баг Хөвсгөл аймгийн Цагаан – Уул сумын нутаг буюу тухайн үеийн Засагт хан аймгийн Эрдэнэ дүүрэгч вангийн хошууны зүүн хойд захын хурал номын газар болох Дордгойн хийдийн тухай сурвалжлага бэлтгэхээр энд Цагаан-Уул сумын хийдийн хамба лам Эрдэнэбат багштай үулзаж байна. Тэгэхээр багш таниас асуухад энэ танай сумын нутагт байдаг Дордгойн хийдийн гарал үүсэл хөгжил, тухайн цаг үедээ хэдэн дугантай, хэдэн ламтай ямар ямар одоо ном хурдаг, шашны ямар ямар зан үйлийг явуулдаг сүсэгтэн олондоо хэрхэн үйлчилдэг байсан тухай ярьж мэдээллээ өгнө үү?

Эрдэнэбат: Дордгойн хүрээ бол 1890-ээд оны үед байгуулагдсан. Тэр хүнхэрвээн даяанч лам, Молом даяанч лам гэдэг арван зургаан наснаасаа наян долоон нас хүртлээ дэмчигийн нямба хийж насаа барсан ийм алдартай хүний гэрийн ором дээр барьсан ийм хийд гэж хөгшчүүл, өвгөн лам нар ярьдаг юм аа. За Энд бол одоо зуун тавиас хоёр зуун ламтай, ер нь л одоо шашны гол төв, майдар эргэдэг, ер нь гол гол хурлуудыг бол бүгдийг нь хурдаг. Тэр хоёр зуун хүн дотор алдартай, бас анх байгуулснаас хойш, хамба, анхны тэр цорж лам нь бол Төр цорж гэдэг хүн байсан. Аа тэгээд тэр Сандаг маарамба энэ тэр гээд, олон л алдартай, би тэр бас залуу байсан болохоор. Тэгээд тэр багш, гэсгүй Цэрэн-Очир, тэр алдартай улсын. Тэр Цэрэн-Очир бол миний багш байсан юм. Тэр бол мянга есөн зуун жаран зургаан, долоон оны алдад нас барчихсан. Тэрнээс жинхэнэ гэсгүй хүн байсан юм. Тэр бүгдийг нь би тэр үед их залуу байсан болоод, бүх нарийн нандин юмыг нь яагаагүй. Тэгээд чог дотроос дэмчигийн чогийг голлож уншдаг. Тэр яагаад вэ гэхлээр анхын тэр шүтэгдсэн лам нь бол дэмчигийн нямба хийж байсан учраас, дэмчигийн. Аа тэгээд яахав, хажидын нямба бүтээл хийсэн лам нар бол бас нэлээн байсан юм байна лээ, тэр талд бол. Хажид дэмчигийн нямба хийсэн, чогийг нь хурдаг. Аа тэгээд л ер нь гол гол чог, найдан чог, маналын чог ямар чог байдаг вэ тэр бүгдийг тэр хоёр зуун лам хуралгүй яахав дээ, тэр. Тэр бүх чогуудыг хурдаг, суваргатай. Тэгээд л тэр дэмчиг, хажидыг их шүтдэг, ядмуудаас л. Чойжингуудаас шалш шүтээнтэй. Дэмчигийн чойжин ч гэдэг, шалш шүтээнтэй тийм хийд байсан юм байна лээ.

Мөнхбат: Тэгэхээр энэ Дордгойн хийдийг бас 1936, 1937, 1938 оноос хар бараан жилүүдийн сүүдэр дайрч өнгөрсөн нь лавтай. Тэгэхээр энэ хийдийн туурийн байдал, тэр дугануудын үлдэгдэл ямар хэмжээнд байна вэ?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Эрдэнэбат: Тэр хийдүүдийн туурь нь бол бараг мэдэгдэхээ байчихсан.Одоо тэгээд л нэг тийм шүтээний дуган байсан юм.Энд нэг тийм дуган байсан гэх тийм таг төдий л юм зөвхөн ор нь л мэдэгдэнэ үү гэхээс бараг одоо юу ч үлдээгүй, ганц шон ч үлдээгүй устсан.Хэлмэгдэлтийн жилүүдэд л устсан, бурхнуудыг нь бол Хатгал руу аваад явсан. Ер нь бол гол гол нандин шүтээн бурхнуудыг нь бол үхэр тэргээр ачаад Хатгал руу л аваад явсан. Тэгээд хил гарсан байх л гэдэг. Ийм л юутай байдаг юм даа.

Мөнхбат: Яриа таамагтай?

Эрдэнэбат: Яриа таамагтай.Би болвол тухайн үед мэдэхгүй, яг.

Өвгөдийн хурал

Мөнхбат: За бид нар Хөвсгөл аймгийн Цагаан-Уул сумын төвөөсөө зүүн хойш гучаад км-т орших Дордгойн хийдтэй ойролцоо, үндсэндээ Дордгойн хийдээс баруун урагшаа найм орчим км-т байгаа Өвгөдийн хурал хэмээн нэрлэгддэг байсан ийм хурлын газрын туурийн тухай судалгааны ажлаа үргэлжлүүлж байна.Тэгэхээр энэ Өвгөдийн хурал гэдэг энэ нэрээрээ академич Ренчин гуайн бүртгэл жагсаалтанд орсон байгаа.Аа гэтэл нутгийн ихэс дээдэс ахмадууд Өвгөдийн хуйн хурал гэж байсан тухай бас нэмэлт мэдээллийг өгч байна.Ингээд Цагаан-Уул сумын , сумын хийдийн хамба лам Эрдэнэбат багштай бид нар уулзаж дараах тодруулгыг авсан юм аа.Тэгэхээр энэ Өвгөдийн хурлын тухай, одоо нэрийн гарал үүсэл ч гэдэг юм уу, ер нь Өвгөдийн хурал гэсэн энэ хурал номын газрын тухай энэ нутгийн ард түмний дунд одоо яриа ам дамжиж хүрсэн бэ? Та одоо багш нараасаа ихэс дээдсээ энэ хийдийн тухай ямар зүйл мэдээллийг сонсож байсан тухай бидэнтэй сэтгэгдлээ хуваалцана уу?

Эрдэнэбат: За Өвгөдийн хүрээ гэдэг бол өвгөн лам нар ихтэй, бүр Богдын хүрээнд алдартай Лувсан аграмба, Буурал аграмба лам гэж, цугаараа шавь учраас нэрийг нь хэлдэггүй, Буурал аграмба, Лувсан аграмба энэ тэр гээд олон аграмба гавж байсан. Хөгшрөөд , орон нутагтаа ирээд, тэр талд бол. Ер нь энэ вангийн хүрээний анхны аграмба гэсэн тэр Өвгөдийн Гоо аграмба гэдэг, тэр Өвгөд талаас төрсөн эрдэмтэй олон тийм аграмба лам нар аграмба гавж энэ тэрүүд насаа хөгшрөхөөр тэр булаг ус сайтай, байгалийн байдал сайтай тийм учраас тэнд очиж хүүхдэд нь хааяа нэг ном заагаад л , хааяа нэг цагийн том том хурлуудад хурчихаад л өвгөн аграмба нар тэгчихээд л тэгж. Тэр Гүнрэгийн сачиг гэж хийж, их хийдэг байсан гэж өвгөн лам нар ярьдаг юм, гүнгэриг гүнгэригийн сачиг дүлцэн хийж биднуудын сачиг дүлцэн хийж, дэмчигжигжид дүйнхор энэ тэрийн тэр сачиг дүлцэн хийж тэр булаг усандаа, Өвгөдийнхөө булагт их өргөдөг байсан.Тэр булгийн ус бол ер нь рашаан болсон , сайхан тунгалаг, хүний дотор их сайн.Тэр олон удаа тэндээс чадалтай лам нар сачиг дүлцэн хийсэн сайн ус гэж ингэж орон нутагтаа алдаршсан, рашаан гэж Өвгөдийн рашаан гэж. За тэр Өвгөдийн заримдаа нэг дөч тавь, заримдаа нэг гуч дөч. За тэгээд тэр гол том хуралд нь гаднаас лам нар иж хурдаг.Тэр байнгын суусан лам нар бол харин Өвгөдийн хуралд бага байсан бололтой юм.Нэг жар дал л орчим байсан юм уу, үгүй юм уу.Тэрнээс нэг их хэтрээгүй гэлтэй.Заримдаа мөн зуу энэ тэр лам нар хурдаг л байсан гэж ярьдаг л юм билээ, томхон хуралд л.Тэрэн дээр хүүхэд сургачихаад л тэр хөгшин лам нар хошуу хүрээ, тэр Цэцэрлэгийнхээ вангийн хүрээ энэ тэр лүү явж дараа шатны гурван уншлагаа дүүргэхихээд хошуу хүрээ Цэцэрлэгийн Эрдэнэ дүүрэгчийн

Энэхүү нэр дурдсан хүний аман ярилцлагын үгчилсэн тэмдэглэл нь зөвхөн ярилцагчийн хувийн мэдээллээс бүрдсэн болно.

© Монголын Урлагийн Зөвлөлийн Соёлын Өвийн Хөтөлбөр, Монголын Сүм хийдийн түүхэн товчоон

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

хүрээндээ л очиж шавилан сууж ном үздэг байсан байна лээ, лав л .Тэрэнд бол жамсран шүтээнтэй, цэдэр хариулахдаа бол хорин нэгэн улаан сэрх авч очсон байдаг гэж өвгөн лам нар ярьдаг.Жамсран шүтээнтэй, тэр Жамсран их шүтдэг.Тийм улааны талын хийд байсан юм уу гэлтэй байдаг юм.

Мөнхбат: За баярлалаа, таньд.

Равданчойнхорлин хийд

Мөнхбат: За манай судалгааны баг өнөөдөр Хөвсгөл аймгийн Цагаан-Уул сумын төв дээр байх Равданчойнхорлин хийдийн хамба лам Эрдэнэбат багштай үулзаж байна аа.Тэгэхээр Эрдэнэбат багшид бид нар одоо шинээр байгуулсан, байгуулагдаад сүсэгтэн олондоо үйлчилж байгаа Равданчойнхорлин хийдийн үүсэл хөгжлийн талаар дараах хэдэн асуултыг тавьсан юм.За эхлээд таньд тавих манай асуулт бол бурхны шажин дахин дэлгэрч мандсан тэртээ 1990-ээд оны үеэс танай хийд шаваа тавьж үүсгэн анхны хурлаа хийж, сүсэгтэн олондоо үйлчилж эхэлжээ.Тэгэхээр тэр цагаас хойш эдүгээ арван тав, арван зургаа, долоо жил өнгөрчээ.Өөрөөр хэлбэл одоо Равданчойнхорлин хийд маань хүнээр яривал эрийн цээнд хүрчээ.Тэгэхээр энэ цагийн дор тэртээ арван тав, зургаан жилийн өмнө байгуулагдаж байсан энэ сүмийнхээ, хийдийнхээ түүхээс одоо та сонирхуулна уу?

Эрдэнэбат: Би энэ ерэн оны гурван сарын хорин нэгэнд Мөрөнд хийд, Мөрөнгийн анх Гандандаржаалингийн дахин сэргэж газар авах ёслолд нь тэнд миний зурхайч Далжаа гэдэг багш байсан учраас тэнд очиж тэр сүм хийдийн газар авах ёслолд нь оролцож байсан юм.Тэгээд ер нь ерэн оноос бол ер нь бурхны шашин наашилж байгаа юм байна, шүтэх бишрэх эрх чөлөө бол жинхэнэ амьдрал дээр хэрэгжих гэж байгаа юм байна гэдгийг тэр цагаас ойлгосон.Тэгээд байж байтал ерэн оны зургаан сарын хорин тавнаас урдах нь суманд албан бичиг ирж, сүсэгтний холбооноос албан бичиг ирж, сүм хийд хурал номын талаар бас мэдэх, одоо шашин номын мэдлэгтэй хүн байвал явуул гэсэн бичиг тоот ирсний дагуу , тэгээд намайг амралтаа аваад, багш байж байх үед тийм бичиг тоот ирлээ гэж захиргаан дээр тус сумын дарга байсан Жадамба дуудаж тэрэнд яваад ирэхгүй юу гэсэн. Би тэгэхээр нь за би одоо ганцаараа бол ч ерөөсөө явж чадахгүй, хоёул гурвуулаа бол явъя, яваад ирье гэсэн.Тэгээд би тэгэхэд сургуулийн багш байсан, хөдөлмөрийн багш. Тэгээд хуучин лам байсан, да хүрээний гэвш Цэрэн гэж өндөр настан.Тэр хүнийг явахгүй юу гэсэн, тэр хуралд явахгүй юу гэсэн.Тэгье, байз.Урд нь би бас тэр хурал номын үйл ажиллагаанд оролцож байсан.Одоо бас энэ чинь юм сэргэхийг үзэх нь үү үгүй юу гэж, тэгье гэж маш дуртай хүлээж авсан.Дараа нь өндөр настан, тэгэвэрт байсан бас сумын дарга энэ тэр хийж байсан, Бүрэнхаан сумын засаг дарга.энд суманд чиг нарийн бичигийн дарга энэ тэр хийж байсан Олдох.Иргэн Олдох гуайг хамт явах уу гэсэн тэгье гэж маш баяртайгаар хүлээж аваад.Ингээд тэр хоёртойгоо хамт яваад ерэн оны зургаан сарын хорин таванд сүсэгтний холбооны анхны хуралд оролцож, маш сайхан үйл явдалд оролцож, тэр хуралд Бакула багш элчин болж ирчихсэн байсан юм.Адис хайрлаж, төв Гандангаас ч их зохион байгуулсан байсан. Маш сайхан хүлээж авч, сайхан хурал болсон.Тэгээд ер нь тэр хурлаас бол ер нь шүтэн бишрэх эрх чөлөө бол жинхэнэ амьдрал дээр хэрэгжиж, одоо хэрэгжиж эхлэх гэж байгаа юм байна гэдэг ойлголтыг аваад, олон газар газрын сайчуул ирсэн байсан.Тэд нартай ингээд саналаа солилцоод,тэгээд ер нь энэ Жалханз хутагт

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

бол, манай суманд таван хүрээ байсан, таван хүрээнээс Ар Дордгойн хүрээ, Агарын хүрээ, Өвгөдийн хүрээ, Далайн хүрээ, Жалханз хутагтын хүрээ гэдэг ийм таван хүрээ байдаг байсан.Тэр дотроос арай алдартай том хүрээ нь бол цам гардаг, таван зуу гаруй лам нартай Жалханз хутагтын хүрээ.Зочин гийчний модон гэр, их үүдний гэдэгтэйгээ арван найман дугантай ч байсан гэдэг, ийм том цам гардаг, гавжийн дамжаа барьдаг ийм том хүрээ байсан гэдэг.Тэгээд энийг ер нь ямар ч байсан олон түмэнд учир байдлыг нь яривал дэмжих байх гэж бодоод баяр наадамд, ерэн оны долоон сарын арван нэгэнд энэ талаар явсан тухайгаа олон түмэнд, ийм үйл явдалд оролцлоо гээд цагаан хоолойгоор мэдээллэхэд олон түмэн бол дуртай хүлээж авсан.Дараа нь есөн аравдаар тэр үед нэг лекцийн тухайгаа нэг уншаад өгөөч гэж тус сумын намын дарга байсан Санжсүрэн бол тэгж зөвлөсний дагуу явсан тухайгаа нэг лекц уншаад орхисон, хөдөлмөрчдийн лекц. Тэгээд ер нь тэр таван сүмээс цугаарангийг нь адис жанлав авсан нэг ганц Равданчойнхорлин гэдэг нэртэй тэр Гэгээний хүрээний цогчин дуганы юуг сэргээж нэг хурал номтой болгоё гэж ингэж олон түмэнд уриалж, лекц уншаад нэг там бирдийн тухай, тамын тухай нэг сайхан зурагтай тийм ном байсан юм.Тэр номыг ингээд гурван зуун төгрөгтэй, ингээд гурван төрлөө бодож,урд бие шашин номын хэрэгт ямар ч байсан урд төрөлдөө оролцож байсан.Одоо төрөлдөө оролцоод, ирээдүй төрөлдөө оролцоё гэж ийм билгийн ерөөл тавиад анхны хандивыг өөрөөсөө гаргаж тэгсэн. Олон түмэн маш дуртай хүлээж авч, тэр лекцэн дээр ингээд хандив хөрөнгө нь бүтэж, сум нэгдэл маань ч одоо маш их дэмжсэн.Таван ханатай Уянгын дунд гарын цоохор гэр, бас мал хөрөнгө хашааны банз энэ тэр хандивлаж нэгдэл, тэр үед нэгдлийн дарга нь бол Батмөнх байсан.Ерөнхий нягтлан нь Гүррагчаа байсан.Энэ хоёр бол бас сумын орлогч. Сумын намын хорооны дарга нь бол Санжсүрэн, сумын дарга нь бол Жадамбаа гэдэг. Бас тэр Жадамбаа гэдэг болвол гэгээний донир байсан Мятав донир гэдэг хүний гэгээний тэр донир хүний удмын Жадамбаа дарга бол бас их дэмжиж, бас сумын дарга байхдаа ингээд.Олон түмэн, төр засгийн удирдлагууд,дэргэтэх нэгдэл энэ тэр дэмжиж, маш хурдан хугацаанд ерэн оны намрын дунд саырн арван долооны билэгт сайн өдөр, тэр есөн сарын хорин нэгэн байсан юм.Тэр өдөр анхны хурлаа арван зургаан ламтай, арван зургаан өвгөн ламтай.Тэр лам нар энэ байдлыг хэлэхэд бол миний багш Дэмчиг маш сайхнаар хүлээн авч, тэр тахил балин, бүх л тэр хуралд юу хурах бүгдийг тэр багш зааварлаж ингээд тэр арван хэдэн лам бүгдээрээ хэлэлцэж.За энээд бол нутгийн лам Хатгалд байсан Жигжсүрэн гуай бол их сайхан халуун дотноор оролцож, Өвгөдийн, Өвгөн хүрээний ууган лам Жигжсүрэн лам бол маш их дэмжиж, бусад лам нь Рагчаа, Очирбат аа тэгээд хоёулаа гэгээний хүрээн дээр сууж байсан.ернь тэр хуучин сумын нарийн бичгийн дарга байсан, тэтгэвэрт орсон, өндөр настан Буд гуай бол бас Гэгээний хүрээний унаган шавь, тийм тийм Цэрэн гэвш гуай бол жинхэнэ Гэгээний хүрээний унаган шавь.Тэгээд бас Улаанбаатарт дээд шатныхаа сургуульд явж, гавжийн дамжаа барьсан ийм лам байсан.Тэд нар бол халуун дотно хүлээж авч, миний тэр сүм байгуулах гэсэн хүслийг их дэмжиж, тэгээд дараа нь анхны хурлаа хурж, цогчин хурлаа хурж наадам хийж, олон түмэнд. Тэрнээс хойш одоо манай хийд үйл ажиллагаагаа явуулж байгаа.Тэгээд би өвгөн лам нараас бол нэг нэг, тэгээд тэр Гэгээний хүрээний жүдийн үнзад байсан, ганцаараа гэлэн ёсоо чиг алдаагүй тийм сайхан өндөр настан лам Пунцагсодов үнзадыг залж ирж, жүдийн их үнзад байсан. Залж ирээд Бүрэнтогтохт байхад нь , Улаанбаатарт

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

тэтгэвэртээ байхад нь , дүүгийнхээ хажууд жижиг гэртэй байхад нь гэртэй нь нүүлгэж ирж нэг тав, зургаан сар энэ хүрээн дээр хурал ямар байх ёстойг тэр хүнээр нэлээн заалгасан. За тэр хүнээр бол цогчин хурлын ая дан, ер нь тэгээд чойжоо дүгжү ямар байх, ер нь тэгээд арван хангал ямар янзтай байдаг юм гэдгийг бол тэр Пунцагсодов унзадаар бол нэлээн заалгасан, тэр хүүхдүүддээ. Тэгээд тэр ламаар бол Сандуйн жүд гэдэг хурлыг ер нь ямар янзтай яаж хүрж байсныг жинхэнэ заалгасан. Дэмчигийн жүдийг, дэмчигийн чог яаж хүрж байсныг бас заалгаж авсан. Надад бол хуучин би судар ном цуглуулах дуртай байсан учраас, багш байхдаа ингээд Хүнхэрваан агуйнаас нэлээн судар ном цуглуулсан байсан. Тэгээд тэр судар номоо надад тэр өвгөн лам бол надад би болвол хурах аргыг мэднэ ээ, судар номноос айгаад хэлмэгдэлтийн үед гэртээ бараг судар номгүй шахуу сууж байдаг, миний юм бол сэтгэл оюундаа л байдаг. Судар ном бол надад байхгүй. Харин чог номыг бол яаж хурахыг би судраа харж байгаад мэднэ ээ гэсэн. Тэгээд тэр дэмчигийг чогийг хурахад бол хаана нь тэр бурхнаа татдаг, ер нь яаж яадаг бүх л юмыг нь болвол тэр унзад байсан учраас сайн мэдэж байсан. Харин тэр тахил балин дээр том хүрээ байсан учраас тус тусдаа мэргэжлийнх шиг байсан сайн мэдэхгүй байсан. Тэгээд би Мөрөнгийн багш Даржаагааас дэмчигийн чог хурахад ер нь тахил балин нь ямар янзтай байдаг юм гэдгийг асуусан. Тэгээд тийм тиймэрхүү байх байх аа гэж ингэж тэр тахил балингийн нь яагаад. Тэр бурхан шүтээн ламын хэрэглэл дэмчигийн юм бол надад байсан учраас би тэр чогийг бас ингэж хүрдаг юм байна аа гэдгийг мэдэж авсан. Их оточ гэдэг хүрлыг бол тэр манай багш Дэмчиг, тэр Жигжсүрэн гуай гэдэг бол бас ерэн дөрөв, таван нас хүрээд өрнөдийн Гандаржаалин хийдэд сууж байгаад өнгөрсөн, ноднин өнгөрсөн. Тэр Жигжсүрэн гуай бол манай эндхийн үндсэн хүн учраас тэр их отчийг яаж хүрж байсныг бол дэглэсэн. Тэгээд тэр тахил балин, юуг яаж хийдгийг самбаатай их уран, тэгээд их хүн чанар сайтай тийм учраас бол тэр лам бол дөрвөн лам хөдөлгөх бүрэн хэрэгсэл энэ тэрийг бол тэр лам өөрөө хийж ирээд. Ингээд тэр манай багш Дэмчиг лам бол анхны нь одоо анхны нь эзэн хамбаар суусан. Дараа нь би хоёрдугаарт орж байгаа юм. Тэр хурал эхлэхэд бол би зүгээр хийдийн зохион байгуулагч номын багш гэж байснаас тэр хамба энэ тэр бол байгаагүй л дээ, тэр багшийг байхад. Багшаас хойш л би иймэрхүү, тэргүүн ловон гэдэг юм, албыг залгуулж. Би нэг хориод хүүхдэд маш түргэн хугацаанд төвд номыг уншдаг бичдэг, багшийн эрдмийн ачаар тийм юм зааж сургасан. Тэгээд тэр хүүхдүүд бол одоо хурал номыг залгуулж байна даа.

Мөнхбат: За бид нарын явсан аймаг сумдын, аймаг сумдад одоо шинээр 1990 оноос бурхны шашин дахин дэлэгрсэн энэ цаг үед шинээр баригдаж ашиглалтанд орсон сүм хийд хурал номын газруудаас одоо зохион байгуулалтын хувьд, дэг жаягийн хувьд, одоо материаллаг баазын идэвхжилтийн хувьд лам боловсон хүчнүүдийн одоо хангалт, хангамжийн хувьд бас арай илүү өндөр түвшинд одоо сумын хэмжээндээ гэхэд одоо бололцооны хэмжээнд бэхжиж хөгжсөн сүм хийд бол танай энэ сүм хийд юм гэж бид бүхэн үзэж байна. Тэгэхээр тэртээх зуугаад жилийн тэртээх монголын төр шашны томоохон зүтгэлтэн хутагтын одоо нэр сүрийг өргөж, хутагтын хүрээг залгамжилж авч явна гэдэг бол нэлээд одоо туйлын хүнд хариуцлагатай бөгөөд нэр хүндтэй хэрэг гэж ойлгож байна. Тэгэхээр энэ хийдэд өнөөдөр ямар ямар ном хүрж байна, за лам нарын боловсон хүчний байдал одоо ямар түвшинд хангагдсан байна, энэ талаар та товчхон мэдээлэл өгөхгүй юу?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Эрдэнэбат: За тэр өвгөн лам нараас нэг нэг хурал аваад байгаа гэсэн, тэр дэмчигийн чог. За тэр хажидын чогийг бол тэр зүүн хүрээний цорж Чимэдравдан багш бол яг өөрөө ирж, залж ирж энд хажидын чогийг ерэн тав, зургаан онд залж ирээд яг ингэж хурдаг гэдгийг урьдчилаад ном судраа бэлдчихсэн байсан учраас тэндээс канондаж олшруулаад тэндээс ном бас тийм найман лам хирээтэй ном хурчихаар ном бэлдчихсэн учраас хажидын чогийг бол их сайхан арван, хорин мтаван хүртэл их сайхан хурдаг юм. За Жигжсүрэн гуай бол өөрөө гүнрэгч хүн байсан. За түрүүний ярьдаг тэр Жигжсүрэн гуайгаар бол гүнрэг яаж хурах, их оточ яаж хурахыг дэглүүлж заалгасан. Аа тэгээд манай хуралд өнгөрсөн хүний хойдхийн буян дорой ерөөл, чогтой гүнрэг хурдаг юм, заримдаа ганжуур хурдаг, ганжууртай. Ганжуурыг лам Буд гуай хийдийн хөрөнгөөр өөрөө Гүмбэн, Утай хоёрыг үзэнгээ явахдаа авчирсан, залж ирсэн. Ингээд за манай арван таванд тэр Пунцагсодов гуайн дэглэсэн Сандуйн жүдийг хурдаг. Битүүнд Найдан чог хурдаг, хорин есөнд ямар нэг, нэг юм уу хоёр хангал тахидаг, шүтээнээ тахидаг. Ийм байнгын хурлуудыг явуулж байгаа. Тэгээд одоогоор шашны ер нь залуу үеийг л бэлдэхгүй бол энэ сүм хийд бол үндсэндээ хурал ном нь тасарч, тэр арван зургаан ламаас ер нь гурван л хүн үлдэж байгаа. Бусад нь бол цаг бус, тэр хорвоогийнхоо жамаар одоо бүрхны оронд заларсан. Одоо нэг нь би байна, тэр наян зургаа, долоо наян долоон настай Буд гуай байна. Аа тэгээд Тогооч гуай наян гурав, дөрвөн ламтай ийм хоёр өвгөн лам л байгаа. Бусад нь дандаа хүүхдүүд. Одоо бол нэг арван хоёр ламтай. Энэнээс хоёр нь бол Улаанбаатарт шашны сургууль төгсөх гэж байгаа. Сууж байгаа, тэр зүүн хүрээний шашны сургуульд. Нэг нь одоо төгсөх дөхөж байгаа, нэг нь одоо ноднин орсон. Бас нэг хүүхэд явсан. Тэр нь одоо Улаанбаатарт өөр сүмд хурал хурж байгаа. Тэгээд эндээ ирэхгүй, тэнд суурьших бодолтой л хүүхэд байх шиг байгаа юм.

Мөнхбат: За таньтай ингээд хуучлаад байвал маш их зүйлийг ярьж болохоор байна. Гэхдээ бидэнд бас ингээд цаг хугацаа дараа дараагийн маань ажил хүлээгдэж байгаа учраас өнөөдрийнхөө энэ ажилтайгаа холбоотой сүүлчийн асуултыг танд тавъя. 19-р зууны сүүлч 20-р зууны эхэн үеийн Монголын шашин төрийн томоохон зүтгэлтэн Халхын тамгатай хутагтүүдийн нэг энэ хутагтынхаа гэгээнтний амьд ахуйдаа идэр залуудаа хэрэглэж явсан одоо шашны болоод ахуйн хэрэглээний эд хэрэглэлийн зүйлээс танай хийдэд нутгийн сүсэгтэн олноор дамжиж ирсэн тийм эд өлгийн зүйлс ямар ямар зүйлс одоо хадгалагдан, өвлөгдөж үлдэв ээ, энэ талаар та сонирхуулж ярихгүй юу?

Эрдэнэбат: За гэгээний сууж байсан олон давхар олбогноос нэг нь тэр гэгээний донир байсан Мятав гэдэг хүний хүү Батцэнгэл гэдэг хүн авчирч өгсөн. Одоо гэгээн багшийнхаа сэнтийн дор тэр олбогийг хийчихсэн байж байгаа. За бас нэг хүнд хадагалагдаж байсан гэгээний хүүхэд насны нэг овоодой бий. Нэлээн тэр Жалханз хутагтын өмсөж байсан. Сууж байсан олбог, дээд овоодой хоёр нь ямар ч байсан дэвсгэр малгай хоёр нь байгаа юм болохлээр дундах нь манай хийдэд лав заларч ирэх байх гэж бодоод би хутагтдаа залбираад. Ямар ч байсан Очирваанийн санжааг цогчин хуралдаа оруулчихсан. Санжаа, сандагдорж магтаалыг байнга хуралдаа уншдаг юм. За тэгээд энэ бол ар Халхад их алдартай, ер нь монголын төр шашны их зүтгэлтэн учраас энийг бол энэ хүрээг сэргээхэд бас наад тал нь манай төв Гандан хийд, цаад тал нь болвол ер нь улс орны зүгээс аймаг орны зүгээс бас нэлээн анхаарч энийг их боловсронгуй шашны сайхан төв болгохын тулд ямар ч байсан бидэнд

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

тусалж дэмжинэ байх гэж энэ ирсэн улсаар дамжуулан хүсэлт тавьж байна. Энэ болвол ер нь ямар ч байсан энэ шашин ном дэлгэрч байгаа цагт очирваанийн бүрэлваа очигжинс лам маань ямар ч байсан энэ өөрийнхөө хүрээн дээр заларч өөд нь татах байх.Тэгээд энийг урьдчиланг бас сайн бэлтгэж боловсон хүчин болоод эд аж ахуй тэр сүм юмыг нь их сайхан тохилог болгоё л гэсэн ийм л бодолтой байна. Тэгээд миний орыг залгамжлагч болвол Сосорбарам гэдэг лам энэ жил шашны сургуульд шалгалт өгнө гээд сая Мөрөнгийн тэр лам нарын зөвлөлгөөнөөс цаашаага явсан.Шашны дээд сургуульд, аа тэр наадах хүүхдүүд бол шашны дунд сургуульд, тэр зүүн хүрээний шашны дунд сургуульд сурч байгаа. Гэхдээ би тэрийг дунд бага гэж бодохгүй, ямар ч байсан их сайхан юм сурч байгаа. Бас орчуулганым дүр орсон.Ер нь тэгээд л балин тахил бүх юмыг их сайхан нарийн сурч ирээрэй, та нар болвол энийг цааш нь...Би болвол яахав энэ хэрээний , нэг номгүй газрыг иймэрхүү хоёр дугантай, тасраад хурчих ямар ч байсан цогчин хурлаа нэгэнд нь хурчих, цог чог хурлаа нэгэнд нь хурчих ийм хоёр ч хурлын савтай байгаа учраас энэн дээр нь цаашаа бэхжиж сайн болох байх гэж энэ залуу шавь нартаа байнга захидаг юм даа.

Мөнхбат: За баярлалаа, таньд. Таны хэлсэн ярьсан энэ үнэтэй мэдээллүүд монголын сүм хийдийн түүхэн товчоо хэмээх манай төслийн үйл ажиллагаа цаашлаад монголын түүх соёлын дурсгалын арвин их санд үнэтэй хувь нэмэр оруулан ач холбогдол болно гэдэгт итгэж байна.За ингээд таньд урт удаан наслахыг хүсэн ерөөе өө.

Эрдэнэбат: За та хоёрын чинь нэр ямар улс билээ?

Мөнхбат: Мөнхбат, Өсөхбаяр.

Эрдэнэбат: За Идгаачойнзонлингийн лам, шашны сургуулийн багш Өсөхбаяр манай хийдийн үйл ажиллагаатай биечлэн ирж танилцсанд маш их талархаж хойшдын буюны үйл болоод шашны боловсон хүчнийг бэлтгэх арвин үйлсдээ маш их өндөр амжилт олж бурхныхаа шашныг өнөд удаан мандуулахад хуварга эрднийхээ үүргийн нэр төртэй биелүүлж урт удаан наслаарай гэж Өсөхбаяр ламдаа хүсэн ерөөе өө.Та чинь хэн билээ, би бас нэг юм хэлээдхэе.

Мөнхбат: Мөнхбат.

Эрдэнэбат: За Мөнхбат, энэ шашин сүм хийдийн судалгаа, ер нь хаана ямар сүм хийд байсан юм энэ талаар дорвитой их судалгаа хийж байгаа түүх нийгэм судлалын багш Мөнхбатдаа маш их баярлалаа.Цаашид нь ажилд нь өндөр амжилт хүсэж буддын шашныг жинхэнэ: монголд үндсэн шашин болгох энэ арвин үйлсдээ өндөр амжилт олж цаашдаа эрдэм ном их түүхээ судалж, үнэнээр нь гаргаж, олон түмэндээ таниулж сурталчилах , залуу үеэ боловсон сайхан хүмүүжүүлэх үйлсдээ их амжилт олж , өөрөө эрүүл энх аз жаргалтай байгаарай гэж хүсэн ерөөж байна даа.

Мөнхбат: За баярлалаа.Тэр ерөөл бат оршиг ээ.

Эрдэнэбат: За танай жолооч хэн билээ?

Мөнхбат: Сүмбээ.

Эрдэнэбат: За Сүмбээ жолооч ч гэсэн аян замдаа осол авааргүй сайхан явж,амьдрал ахуйгаа цэцэглүүлэн хөгжиж, бурхны шашныхаа үйлд улам их үнэтэй хувь нэмэр оруулаарай гэж та бүхнээсээ хүсэн ерөөе өө.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Мөнхбат: За баярлалаа, тэр ерөөл бат оршиг ээ.Их сайхан ерөөл хайрласан таньд баярлалаа.